



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОНТУУЛ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
АРДЧИЛСАН НАМД

2024. 08. 06 № 1НАГ-2024/З-ЦТА-НА-27  
танай -ны № -т

### Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

#### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

#### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгур болгосон.

### Дүгнэлт


Ардчилсан намын Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Орхонтуул сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр ( .....3..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Орхонтуул сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СҮМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**НЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙ:**

1. Сүмүн төв болон Рашаант тосгоны төвүүдэд баригдсан сүү хөргүүрийн цехүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
2. Хөдөөгийн хүн ам, мал аж ахуйн усан хангамжийг сайжруулах замаар бэлчээрийн худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлж, алслагдсан бэлчээрийг бүрэн ашиглана.
3. Малын үүлдэр угсааг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлж, өндөр ашиг шимт үүлдрийн үржлийн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж ажиллана.
4. Малын гаралтай сүү, сүүн бүтээгдэхүүн, цагаан идээгээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэдийг бодлогоор дэмжиж, зах зээлд нийлүүлэх боломжийг хангах талаар хамтарч ажиллана.
5. Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах цех жижиг үйлдвэрүүдийг бий болгож буй иргэн аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана.
6. Мал эмнэлэг үржлийн тасаг, мал эмнэлгүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс тавих хяналтыг нэмэгдүүлэх замаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж, малчдыг мэдээллээр бүрэн хангаж "Эрүүл малтай сум" болно.
7. Залгамж халаа болж буй "Залуу малчин, тариаланчид"-ыг бодлогоор дэмжиж ажиллана.
8. Хагас болон бүрэн эрчимжсэн мал, аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
9. Тариалангийн газар эзэмших, ашиглах эрхийн хяналтыг сайжруулж, хөрсний үржил шимийг бууруулсан нөхцөлд эзэмших, ашиглах эрхийг цуцлах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч, хяналт тавьж ажиллана.
10. Газар тариалан, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн аж ахуй эрхлэгч иргэн аж ахуйн нэгж, байгууллагыг техник технологи шинэчлэх, хүлэмжийн аж ахуйн төсөл хөтөлбөрт хамрагдах асуудлыг бодлогоор дэмжиж ажиллана.
11. Хадланчдын хадлангийн талбайг ашиглах гэрээг 6 дугаар сард хийж, хадлангийн талбайгаа хамгаалах, үр бордоо цацах, ургац нэмэгдүүлэхэд анхаарч, хамтарч ажиллана.

**ХОЁР. ДЭД БҮТЭЦ:**

1. Рашаант тосгонд залуучуудын чөлөөт цагийг өнгөрөөх шинэ "Спорт заал" барьж, ашиглалтад оруулах санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжүүлнэ.

2. Орхон гол дээгүүр тавигдах гүүрний ажлыг дуусгаж, "Атараас-Баруунбүрэн" хүртэлх засмал замыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

3. Орхонтуул суманд хөдөө аж ахуй, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж сум орон нутагтаа бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэнэ. МЮА0065 9055436

4. Рашаант тосгоны гэр хороолол, гудамж талбайг сайжруулсан замтай болгоно.

5. Гэр хорооллын гудамж талбайд байгаа малын гаралтай хог хаягдлыг бүрэн цэвэрлэнэ.

6. Сумын хэмжээнд үерийн усанд эвдэрч нурсан зам, давааг засварлана.

7. Баянцогтын 2 дугаар баг, Рашаант тосгоны орон сууцны байрнуудын дунд ногоон байгууламж бүхий хүүхдийн тоглоомын талбай бүхий тохилог орчин бий болгоно.

8. Сумын төвийн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг шинэчлэх ажлыг зохион байгуулна.

#### **ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНД:**

1. Эрүүл мэндийн даатгалаас олгодог эмийн хөнгөлөлтийг тэгш хүртээмжтэй олгоход анхаарч, эм зүйн боловсон хүчнээр ханган, тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэн ажиллана.

2. Явуулын эмнэлгийн үйлчилгээг нэвтрүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

3. Эрүүл мэндийн төвийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг орчин үеийн стандарт шаардлагад нийцүүлэн үе шаттайгаар шинэчлэх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

#### **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэний нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлсэн үйлчилгээг бодлогоор дэмжинэ.

2. Шилдэг багш, суралцагчдыг гадаад, дотоодын сургуулиудад суралцуулах, дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.

3. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрыг шинээр барих ажлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлан, санхүүжилтийг улс, орон нутгийн төсөвт суулгуулах ажлыг зохион байгуулна.

#### **ТАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ:**

1. "Өрх бүр - Ажлын байр" хөтөлбөрийг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэнэ.

2. Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого, хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжиж, хамтран ажиллана.

3. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн аж ахуйн

нэгжүүдтэй хамтран зорилтот бүлэг, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

4. Эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах төсөл хөтөлбөр, санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.

#### ЗУРГАА. ЗАСАГЛАЛ:



1. Төрийн байгууллагын үйл ажиллагааг хүртээмжтэй, нээлттэй болгож төрийн албан хаагчдыг хүнд сурталгүй, авилгаас ангид байх нөхцөлийг бүрдүүлж, "Авлигагүй нээлттэй цахим сум" болгох зорилт тавин ажиллана.

2. Орон нутагтаа "Бүтээлч", "Бүтээгч" засаглалыг бий болгоно.

3. Жил бүрийн хавар, намар сумын хэмжээнд Засаг даргын нэрэмжит үзлэг явуулж, аж ахуйн нэгж, албан байгууллага, гудамж хорооллын тохижилт, соёлжилтод хяналт тавьж, зөрчил арилгах тал дээр зэмжлэг үзүүлнэ.

4. Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн зарцуулалт, шалгаруулалтыг иргэдэд ил тод, цахим болгоно.

5. "Хашаандаа сайхан амьдаръя" хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрх бүрийг ногоон байгууламж байгуулах нөхцөл бололцоог хангах бодлого баримтлан ажиллана.

6. Хүүхдийг ёс суртахуун, зан заншлын буруу зуршилд авталаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд гэр бүл, сургууль олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

7. Хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

8. Сумын хурдан морин уралдааны замыг тогтоон, замын нөхцөлийг сайжруулж, унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажлыг хүүхэд хамгааллын байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллана.

9. Төмөр замын байгууллага аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллана.

10. Гадаад орнуудын болон бус нутгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн ижил түвшний бус, мужтай холбоо тогтоож туршлага судлан хамтран ажиллах бодлого баримтлан ажиллана.

11. Хүний эрхийг хамгаалахад төрийн байгууллага. иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

#### ОРХОНТУУЛ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО